

НИЙГМИЙН ДААТГАЛЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН АВЛИГЫН ЭСРЭГ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Д/д	Хэрэгжүүлэх ажил	Биелэлт
1	<p>Авлигын эсрэг үйл ажиллагааг төлөвлөх, тайлагнах ажлыг зохион байгуулах</p>	<ul style="list-style-type: none"> • НДЕГ-ын хэмжээнд авлигын эсрэг үйл ажиллагаа явуулах төлөвлөгөөг боловсруулж, батлуулах, АТГ-т хүргүүлэх • Төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулах • Тайланг нотлох баримтын хамт хүргүүлэх • Орон тооны эрх бүхий албан тушаалтантай болох
2	<p>МУ-ын Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд нийгмийн даатгалын чиглэлийн бодлогын баримт бичгүүдийг боловсруулж, батлахад санал оруулах</p>	<p>“Эрүүл мэндийн албан журмын даатгалын тухай хууль”-ийн төслийг УИХ-ын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэхээр шийдвэрлэсний дагуу хуулийн төслийг бэлтгэх Ажлын хэсэг, Ажлын дэд хэсгийн бүрэлдэхүүнд орж ажилласан. Энэ ажлын хүрээнд Нийгмийн бодлого, Боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хороо, НҮБ-ын хөгжлийн сантай хамтран “Эрүүл мэндийн албан журмын даатгалын тухай” хуулийн төслийн хэлэлцүүлгийг 2014 оны 10 дугаар сарын 24-ний өдөр Төрийн ордонд зохион байгуулж, төрийн захиргааны төв болон бусад байгууллагууд, төрийн бус байгууллагууд, эрүүл мэндийн байгууллагууд, олон улсын байгууллагуудын төлөөллүүдийг оролцуулсан.</p>
3	<p>Авлигын эсрэг хууль тогтоомжийг сурталчлах, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах</p>	<ul style="list-style-type: none"> • Авлига, хувийн ашиг сонирхолтой холбоотой хууль, тогтоомжийг албан хаагчдад танилцуулах, сурталчилгаа хийх ажлыг нийгмийн даатгалын салбарын хэмжээнд тогтмол явуулж хэвших • Салбарын хэмжээнд энэ чиглэлээр хийсэн ажлыг дүгнэж, үр дүнг тооцох <p>• НДЕГ-ын хувийн ашиг, сонирхол, хөрөнгө орлогын мэдүүлэг гаргадаг албан хаагчдад 1 цагийн сургалт зохион байгуулж, ХАСХОМ-ийг хэрхэн үнэн зөв гаргах талаар АТГ-ын ажилтан Л.Анхныбаяраар мэдээлэл хийлгэж, гарын авлага тараасан. Нийгмийн даатгалын төв, орон нутгийн байгууллагын удирдах албан тушаалтнуудад 2014 оны 04 сарын 24-ний өдөр 1.30 цагийн мэдээлэл хийж, АТГ-ын ажилтан Л.Анхныбаяраар мэдэгдэл тайлбар хэрхэн гаргах, сул ажлын байранд судлагдаж байгаа хүний хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг хэрхэн авах, ЭБАТ-ыг удирдан чиглүүлэхэд анхаарах</p>

НИЙГМИЙН ДААТГАЛЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН АВЛИГЫН ЭСРЭГ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

		<ul style="list-style-type: none"> • Байгууллагын цахим хуудсаар дамжуулан авлига, хувийн ашиг сонирхолтой холбоотой хууль тогтоомжийг иргэдэд сурталчлах ажлыг зохион байгуулах • АТГ-аас бүрэн эрхийнхээ дагуу гаргасан шийдвэр, зөвлөмжийг хэрэгжүүлэх • Удирдлагаас гаргасан тушаал шийдвэрүүдийг сурталчлах, нээлттэй ил тод байлгах 	<p>зүйлийн талаар мэдээлэл хийлгэж, мэдэгдэл тайлбар гаргах дадлага хийлгэсэн. Сургалтанд оролцогчдод АТГ-аас эмхтгэн гаргасан хууль тогтоомжийн эхмтгэл, гарын авлага 3 төрлийн материал 70 ширхэгийг тарааж өгсөн.</p> <ul style="list-style-type: none"> • Тэтгэврийн байцаагч (ажилтан)-ийн чадавхийг дээшлүүлэх сургалтын үеэр нийгмийн даатгалын орон нутгийн байгууллагуудын тэтгэврийн байцаагч нарт ХАСХОМ-ийг хэрхэн үнэн зөв гаргах, хуулинд заасан хугацаа, мэдэгдэл тайлбарыг хэрхэн зөв гаргах талаар АТГ-ын ажилтан Л.Анхныбаяраар 2 цагийн мэдээлэл хийлгэж, заавар зөвлөгөө өгч, хөрөнгө орлогын мэдүүлэг гаргагч нарт зориулсан зөвлөмж 64 ширхэгийг тараасан. • АТГ-ын Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтэс, хяналт шалгалт, дүн шинжилгээний хэлтэстэй хамтран 2014 оны 11 сарын 03-06-ны өдрүүдэд Авлигын эсрэг хууль тогтоомжийг сурталчлах, Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль сурталчлан таниулах сургалт зохион байгуулж, нийт 63 ажилтан (албан хаагч)-ыг оролцуулсан. • Нийгмийн даатгалын төв, орон нутгийн байгууллагуудын удирдлагуудын 2013 оны ажлын үр дүнг дүгнэхдээ авлига, хувийн ашиг сонирхолтой холбоотой хууль, тогтоомжийг сурталчлах, хэрэгжүүлэх чиглэлээр хийсэн ажлыг харгалзан үзэж, тайлан мэдээг татан авч, дүгнэх ажлыг хийж байна. Цаашид жилийн эцсээр ажлын үр дүнг тооцож, газар (хэлтэс)-ын даргын үр дүнгийн гэрээг дүгнэх үнэлгээнд тусгайлан оруулж дүгнэх юм. • Байгууллагын www.ndaatgal.mn цахим хуудасны Хууль, эрх зүй буланд Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, НДЕГ-ын даргын нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон тушаалуудыг тогтмол байршуулж, иргэдэд нээлттэй сурталчилж, мэдээлэл авах боломжийг олгож ажилласан.
--	--	--	--

НИЙГМИЙН ДААТГАЛЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН АВЛИГЫН ЭСРЭГ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

			<ul style="list-style-type: none"> • АТГ-аас ирсэн “Хуулийн хэрэгжилтийг хангах тухай”, “Бэлтгэл хангуулах тухай” 2 төрлийн зөвлөмжтэй танилцаж, НДЕГ-ын ТСБГазар, орон нутгийн НДХ-ийн эрх бүхий албан тушаалтнуудад чиглэл өгч, зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулан, хийсэн ажлын тайланг заасан хугацаанд нь Авлигатай тэмцэх газарт хүргүүлсэн. • Байгууллагын дотоод сүлжээний зар мэдээгээр (http://10.9.0.5/zarmedee/) удирдлагаас гаргасан тушаал, шийдвэрүүдийг тараах, сурталчлах ажлыг Тамгын газрын тогтоол шийдвэрийн биелэлт хариуцсан ажилтнаар сар бүр тогтмол байрлуулж ажилласан.
4	<p>Нийгмийн даатгалын салбарын хэмжээнд дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон шийдвэрийг цахим хуудсанд тогтмол байршуулж, иргэдэд нээлттэй сурталчлах</p>	<ul style="list-style-type: none"> • Шийдвэрүүдийг байршуулж олон нийтэд сурталчлах буланг байгууллагын цахим хуудсанд нээж, тогтмол ажиллуулах • Хэм хэмжээ тогтоосон шийдвэрүүдийн жагсаалтыг АТГ-т хүргүүлж хэвших 	<ul style="list-style-type: none"> • Нийгмийн даатгалын салбарын хэмжээнд дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон, чиглэл өгсөн тушаал шийдвэрүүдийг байгууллагын www.ndaatgal.mn цахим хуудас болон салбарын дотоод сүлжээний зар мэдээгээр дамжуулан тогтмол сурталчлах, түгээх, хэрэгжүүлэх ажлыг тайлант хугацаанд Мэдээллийн технологийн төвтэй хамтран хийж гүйцэтгэсэн. • “Ажилласан жил, нийгмийн даатгалын шимтгэлийг нөхөн тооцох тухай” хууль, “Иргэдийн эрүүл мэндийн даатгалын тухай хууль”-ийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд иргэдийн ажилласан жил, нийгмийн даатгалын шимтгэлийг нөхөн тооцох, тасралтгүй эрүүл мэндийн даатгалын шимтгэл төлсөн иргэнийг урамшуулах талаар гарсан журам, чиглэлийг байгууллагын facebook хаяг, www.ndaatgal.mn цахим хаягаар иргэдэд сурталчилж, мэдээллээр хангаж ажилласан. Ажилласан жил, нийгмийн даатгалын шимтгэлийг нөхөн тооцуулсан эсэх, эрүүл мэндийн даатгалын хөнгөлөлтөнд хамрагдсан эсэхийг шалгах боломжийг иргэдэд олгож, байгууллагын цахим хуудсанд шууд холбоос байрлуулсан. Дээрх хууль, журмыг хэрэгжүүлэх ажлын явцын талаар НДЕГ-ын дарга болон холбогдох албан тушаалтнууд ZA, ETV, MNAгентлаг, MNC телевиз, Эх орон, NBC, SBN зэрэг телевизүүдээр дэлгэрэнгүй мэдээлэл хийж, иргэдэд сурталчилсан.

НИЙГМИЙН ДААТГАЛЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН АВЛИГЫН ЭСРЭГ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

5	НДЕГгазраас гадагш чиглэсэн шалгалтыг олон нийтэд нээлттэй болгох ажлыг зохион байгуулах	<ul style="list-style-type: none"> • НДЕГгазраас 2014 онд хийх гадагш чиглэсэн шалгалтын хуваарийг байгууллагын цахим хуудсанд байршуулж хэвших • Хяналтын ажлын үр дүн, авсан арга хэмжээний талаар мэдээлэл хийх 	<ul style="list-style-type: none"> • Хяналт, шинжилгээ үнэлгээний газраас 2014 онд хийсэн гадагш чиглэсэн хяналт шалгалтын ажил, шалгалтын мөрөөр авсан арга хэмжээний мэдээг байгууллагын цахим хуудсанд байршуулж, мэдээлэл авах боломжийг бүрдүүлсэн.
6	Төсвийн орлого, зарлага, хандив тусламжийн хөрөнгө, хэрэгжих төсөл хөтөлбөрийг нээлттэй байлгах	<ul style="list-style-type: none"> • 2013 оны төсвийн зарцуулалтын тайланг олон нийтэд мэдээлэх • 2013 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлтийн талаарх мэдээллийг цахим хуудсаар дамжуулан сонирхогч бүлгүүдэд мэдээлэх • НДЕГ-ын 2014 оны төсвийн мэдээллийг нээлттэй болгох • НДЕГ-ын 2015 оны төсвийн төслийн мэдээллийг нээлттэй болгох • 2014 оны төсөвт орсон өөрчлөлтийн талаарх мэдээллийг цахим хуудсанд байршуулах • Нийгмийн даатгалын сангийн орлого, зарлагын бүрдүүлэлтийн талаарх мэдээллийг ил тод байлгах • Тайлант хугацаанд хэрэгжсэн төсөл хөтөлбөрийн талаар олон нийтэд мэдээлэл хийх ажлыг зохион байгуулах 	<ul style="list-style-type: none"> • 2013 оны төсвийн гүйцэтгэл, 2013 оны аудитын дүгнэлт хийгдсэн тайланг дүгнэлтийн хамт, байгууллагын www.ndaatgal.mn цахим хуудасны мэдээллийн ил тод байдал буланд байршуулж олон нийтэд мэдээлсэн. • 2014 оны төсөв болон тодотгосон төсөвийг www.ndaatgal.mn цахим хуудасны мэдээллийн ил тод байдал буланд байрлуулж, олон нийтэд мэдээлэл авах боломжийг бүрдүүлсэн. • 2015 оны төсвийн төслийн мэдээллийг www.ndaatgal.mn цахим хуудасны мэдээллийн ил тод байдал буланд байрлуулж, иргэдэд мэдээлэл авах боломжийг бүрдүүлсэн. • Нийгмийн даатгалын сангийн орлого, зарлагын сар бүрийн цахим мэдээллийг сар бүрийн 5-ны өдөр ТСБГ-аас тогтмол гаргуулан авч, www.ndaatgal.mn цахим хуудасны статистик үзүүлэлт буланд тогтмол байршуулж байна. • Тайлант хугацаанд хэрэгжиж байгаа төсөл хөтөлбөрийн талаар байгууллагын facebook хаягаар тогтмол мэдээлж, www.ndaatgal.mn цахим хуудасны мэдээллийн ил тод байдал буланд төсөл, хөтөлбөрийн жагсаалтыг, дэлгэрэнгүй мэдээлэл оруулж, сурталчилсан. • Тайлант хугацаанд НДЕГ-ын хэмжээнд хэрэгжиж байгаа төсөл хөтөлбөрийн жагсаалтыг АТГ-т хүргүүлсэн.

НИЙГМИЙН ДААТГАЛЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН АВЛИГЫН ЭСРЭГ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

		<ul style="list-style-type: none"> Хэрэгжих хөтөлбөрүүдийн жагсаалтыг хүргүүлэх төсөл АТГ-т 	
7	Хүний нөөцийн бодлогын ил тод байдлыг хангах	<ul style="list-style-type: none"> Салбарын хэмжээний сул ажлын байрны мэдээллийг цахим хуудсанд байршуулж хэвших Тайлант хугацаанд шинээр томилогдсон албан тушаалтны жагсаалтыг гаргаж, АТГ-т хүргүүлэх Шинээр томилогдож байгаа албан тушаалтнаас хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг авч, АТГ-т хүргүүлэн санал авах, албан тушаалтнуудын хөрөнгө ордогын мэдүүлгийг авч баталгаажуулах Төрийн албан хаагчийн ажил үүргийн чиглэлийн мэдээллийг байгууллагын цахим хуудсанд байршуулах Албан хаагчдад давхар ажил эрхлэх зөвшөөрлийг олгох, давхар ажил эрхлэлтийн судалгааг гаргах ажлыг зохион байгуулах Нийгмийн даатгалын ажилтнуудын мөрдөж ажиллах хууль, тогтоомж, шийдвэрийг хэрэгжүүлэх талаар арга зүйн зөвлөмж, аргачлал боловсруулж ажилтнуудад хүргэх 	<ul style="list-style-type: none"> Тайлант хугацаанд сул ажлын байр гараагүй бөгөөд салбарын хэмжээнд албан хаагчдыг сэлгүүлэн ажиллуулсан. Шинээр томилогдохоор судлагдаж байсан 26 хүнд хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг хэрхэн зөв гаргах талаар заавар зөвлөгөө өгч, мэдүүлгийг үнэн зөв гаргуулан авч, төрийн албан хаагчийн анкет, нэр дэвшиж байгаа ажлын байрны тодорхойлолт, өмч хөрөнгө, хуулийн этгээдийн лавлагааны хамт АТГ-т хүргүүлэн дүгнэлт гаргуулах ажлыг тогтмол хийж ирсэн. Шинээр томилогдсон албан тушаалтнаас хуулийн хугацаанд багтаж, ХАСХОМ-ийг гаргуулан авч, хянаж баталгаажуулах, цахимаар болон цаасаар бүртгэх ажлыг тогтмол хийж гүйцэтгэсэн. Нийгмийн даатгалын төв, орон нутгийн байгууллагуудаас давхар ажил эрхлэлтийн судлагааг гаргуулан авч, нэгтгэж байна. Судалгааны дүнд салбарын хэмжээнд нийт 2 албан хаагч удирдлагын зөвшөөрөлтэйгөөр хуулийн дагуу давхар ажил эрхэлж байна. Нийгмийн даатгалын ажилтнуудын мөрдөж ажиллах хууль, тогтоомж, заавар зөвлөмжүүдийг байгууллагын www.ndaatgal.mn цахим хуудас, салбарын дотоод сүлжээний зар мэдээгээр дамжуулан тогтмол сурталчилж, судлуулах, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж байна. Тайлант хугацаанд нийт 44 арга зүйн зөвлөмж, чиглэлийг боловсруулан баталгаажуулж, ажилтнуудад хүргүүлэн, хэрэгжүүлж ажилласан. Улсын байцаагчийн эрх олгох, сэргээх шалгалтын төстийг байгууллагын www.ndaatgal.mn цахим хуудас, салбарын дотоод сүлжээнд нээлттэй байршуулж, шалгалт авах журам, дэгийн талаар НДЕГ-ын удирдлагууд орон нутгийн нийгмийн даатгалын байгууллагуудын дарга нартай

НИЙГМИЙН ДААТГАЛЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН АВЛИГЫН ЭСРЭГ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

			цахим хурал хийж мэдээлэл хийсэн. Шалгалтыг салбарын хэмжээнд 2014 оны 09 сарын 15 – 10 сарын 09-ний өдрийг хүртэлх хугацаанд цахим хэлбэрээр авч, дүнг тооцож гаргасан.
8	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг нээлттэй байлгах	<ul style="list-style-type: none"> • Худалдан авах ажиллагааны 2014 оны төлөвлөгөөг нээлттэй танилцуулах • Худалдан авах ажиллагааны 2015 оны төлөвлөгөөний төслийг нээлттэй танилцуулах • Худалдан авах ажиллагаанд оролцсон болон шалгарсан аж ахуйн нэгжийн мэдээллийг ил тод байлгах 	<ul style="list-style-type: none"> • НДЕГ-ын 2014 оны бараа, ажил, үйлчилгээ худалдан авах төлөвлөгөөг www.ndaatgal.mn цахим хуудасны мэдээллийн ил тод байдал буланд байршуулсан. • 2014 оны худалдан авах ажиллагаатай холбоотой мэдээллийг, эхний хагас жил болон 3-р улирлын худалдан авах ажиллагааны тайлангийн хамт байгууллагын www.ndaatgal.mn цахим хуудсанд мэдээллийн ил тод байдал буланд байрлуулсан.
9	Авлигын эрсдэл ба авлига гарах боломжийг бууруулах, урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах арга хэмжээ авах	<ul style="list-style-type: none"> • Авлигад өртөх эрсдэлтэй албан тушаал, үйлчилгээний жагсаалтыг тодорхой судалгаан дээр үндэслэн гаргах • Энэ төрлийн ажил, үйлчилгээ эрхэлдэг албан тушаалтныг хянах нөхцөл боломжийг бүрдүүлэх • Авлигын эрсдэл ба авлига гарах боломжийг бууруулах чиглэлээр тодорхой арга хэмжээ авч хэрэгжүүлэх • Газрын удирдлага авлигатай тэмцэх хүсэл, эрмэлзлэлээ илэрхийлж, авлигыг үл тэвчих, ёс зүй, шударга ёсыг эрхэмлэн ашиг сонирхлын зөрчилгүй ажиллах талаар олон нийтэд мэдээлэл хийх • Ажилтнуудын ёс зүйг дээшлүүлэх, авлигаас 	<ul style="list-style-type: none"> • Нийгмийн даатгалын төв, орон нутгийн байгууллагуудын хэмжээнд авлигын эрсдэл үүсэх, авлига гарах боломжийг хаах зорилгоор “Бид авлигыг хэрхэвч зөвшөөрөхгүй” зурагт хуудас 3000 ширхэгийг хэвлүүлж, байгууллагуудад тарааж байрлуулсан. Энэ ажилд байгууллагын төсвөөс 2,1 сая төгрөгийг зарцуулсан. • Тус газрын даргын санаачлагаар авлигын эрсдэлийг бууруулах, хууль бус үйлдлийг илрүүлэх, таслан зогсоох арга хэмжээ авсан албан хаагчийг жилийн ажлын үр дүнгээр урамшуулахаар шийдвэрлэж, “Нийгмийн даатгалын байгууллагын шударга үйлстэн” шагналын журмыг шинээр боловсруулсан. • АТГ-ын Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтэс, хяналт шалгалт, дүн шинжилгээний хэлтэстэй хамтран 2014 оны 11 сарын 03-06-ны өдрүүдэд Авлигын эсрэг хууль тогтоомжийг сурталчлах, Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль сурталчлан таниулах сургалт зохион байгуулж, нийт 63 ажилтан (албан хаагч)-ыг оролцуулсан.

НИЙГМИЙН ДААТГАЛЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН АВЛИГЫН ЭСРЭГ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

		сэргийлэх, гэгээрүүлэх сургалт, зөвлөгөөн байгуулах	соён талаар зохион	
--	--	--	--------------------------	--